



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС**

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.МӨНХТУЯА ТАНАА

2025.09.04 № 01/1536
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 32 дугаартай албан бичгээр ирүүлсэн асуулттай танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Нэг.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-аар 26 ба түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар олгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг зөрчиж байгаа эсэх талаар:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, ингэхдээ эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, цалин хөлс нь түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгохуйц байна гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулиар цалин хөлс авах, үл ялгаварлан гадуурхах үндсэн эрх, суурь зарчмыг баталгаажуулсан.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн удиртгал хэсэгт амьжиргаа хангахуйц цалин олгох, ижил үнэлэмж бүхий ажилд адил тэгш цалин хөлс олгохыг баталгаажуулах нь чухал болохыг онцолсон байдаг. Мөн Тэгш шан хөлс олгох тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенцын 2 дугаар зүйлд “Гишүүн улс бүр шан хөлсний хэмжээг тогтоох аргад нийцүүлэн адил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилчдад тэгш шан хөлс олгохыг дэмжиж, уг зарчмыг бүх ажилчдын хувьд хэрэгжүүлнэ” гэж заасан.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс бүрд энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэг хүлээсэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийн талаарх Ерөнхий зөвлөмж 23-т “бүх ажилтан шударга хөлс авах эрхтэй. Шударга хөлс нь зөвхөн ажлын үр дүнгээс гадна ажилтны гүйцэтгэх үүрэг, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах боловсрол болон ур чадварын төвшин, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө, ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хүндрэл бэрхшээл, ажилчдын хувийн болон гэр бүлийн амьдралд үзүүлэх нөлөө зэргийг харгалзан үзсэн байна” гэж тусгасан. Мөн уг зөвлөмжийн 3 (ямар ч

150022333

төрлийн ялгаварлалгүйгээр ижил үнэ цэнтэй ажилд тэгш цалин олгох, тэр дундаа эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс дутахааргүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, ижил ажилд ижил цалин олгох)-т “Ажилчид ижил эсвэл ижил төстэй ажлыг гүйцэтгэхдээ ижил цалин авахаас гадна тэдний ажил огт өөр боловч бодит шалгуураар үнэлэгдэхэд ижил үнэ цэнтэй байсан ч тэдний цалин тэнцүү байх ёстой. Энэхүү шаардлага нь зөвхөн цалин хөлснөөс гадна ажилчдад шууд болон шууд бусаар олгосон бусад төлбөр, тэтгэмжийг багтаасан болно” гэж тайлбарласан байна.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөгжиж буй орнуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай” 131 дугаар конвенцын гуравдугаар зүйлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний түвшинг тогтооход ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг улсын ерөнхий түвшин, амьжиргааны өртөг, нийгмийн бусад бүлгийн амьжиргааны түвшин, эдийн засгийн хөгжлийн шаардлагууд, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан үзэхээр заасан.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Оролцогч улсуудын үүрэг (Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактын 2-р зүйлийн 1 дэх хэсэг)-ийн тухай Ерөнхий зөвлөмж 3-т “байгаа бүх боломжийнхоо хэрээр” гэсэн нь оролцогч улс орнууд өөрсдийн нөөц бололцоо, чадавх, нөхцөл байдлыг харгалзан, эрхийн хэрэгжилтийг үе шаттайгаар хангах үүрэг хүлээж байгааг илэрхийлсэн. Тус зөвлөмжид “аажмаар хангах” гэдэг нь эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхүүдийг шууд, богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдлыг хүлээн зөвшөөрсөн үзэл баримтлал бөгөөд эдгээр эрхийн хэрэгжилтийг бодит нөөц бололцоонд тулгуурлан шат дараатайгаар хангахыг зорьсон бодлого гэж тайлбарласан байна.

Олон улсын гэрээ, конвенц нь хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, шударга цалин хөлс авах, тэгш байх, амьдралын зохистой түвшинд нийцсэн байх зэрэг үндсэн эрх, суурь зарчим, нөхцөлийг тогтооход чиглэх бөгөөд харин тухайн улс орон бүр эдийн засгийн хөгжил, төсөв, санхүүгийн чадавх зэрэг нөөц бололцоондоо тулгуурлан цалин хөлсний бүрдэл хэсэг, түүний хэмжээ, шалгуурыг дотоодын хууль тогтоомжоор тогтоох эрхтэй байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар цалин хөлс авах, үл ялгаварлан гадуурхах эрхийг баталгаажуулж, цалин хөлсний нарийвчилсан бүтэц, тэдгээрийн хэмжээг тогтоох эрх зүйн үндэслэлийг зохицуулсан. Төрийн үйлчилгээний албан хаагчид олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4-д зааснаар цалин хөлсний бүрдэл хэсэг бөгөөд энэхүү нэмэгдэл олгох журам, хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор хуульчилсан байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 6-10 жилд 5 хувь, 11-15 жилд 10 хувь гэх мэтээр 5 хувийн давтамжтайгаар 25 хувь хүртэл нэмэгдэл олгож байсныг ажилласан жил бүрээр олгохоор өөрчлөн найруулсан нь төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх болон үл ялгаварлан гадуурхах эрхийг хангахад чиглэсэн, нийгмийн баталгааг дээрдүүлсэн зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Засгийн газар дотоодын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүний хэмжээг ажилласан жилтэй нь уялдуулан ялгамжтай тогтоосон нь олон улсын гэрээгээр тогтоосон хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцсэн, цалин хөлс авах, үл ялгаварлан гадуурхах эрхийг хангахад чиглэж байна.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамааран өсөн нэмэгдэх итгэлцүүр”-ээр аймгийн төвийн сум, аймгийн төвөөс бусад сум, нийслэлд байршилтай төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагчийн тооноос хамааран итгэлцүүрийг ялгамжтай тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг зөрчиж байгаа эсэх талаар:

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүний сурч боловсрох үндсэн эрхийг хүн бүрд баталгаатай эдлүүлэх нь улс орны Засгийн газрын үүрэг бөгөөд Монгол Улс энэхүү үүргээ бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж байна. Боловсролын ерөнхий хуулиар боловсролын үйл ажиллагаа нь тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх суурь зарчимд тулгуурлахаар зохицуулсан нь хүн амын бүхий л бүлгийн хүүхдийн сурч боловсрох эрхийг баталгаатай эдлүүлэхэд чиглэгджээ.

Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн болон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамааран өсөн нэмэгдэх итгэлцүүрийг тогтоосон байна.

Уг тогтоолоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамааран өсөн нэмэгдэх итгэлцүүрийг тогтоохдоо байршлаар нь нийслэл, аймгийн төвийн сум, аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар өөр өөр тооцож, аймгийн төвөөс бусад сумын итгэлцүүрийг өндрөөр тогтоожээ. Түүнчлэн суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүрийг мөн адил нийслэл, аймгийн төвийн сум, аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар суралцагчийн тооноос хамаарч итгэлцүүрийг бууруулан газарзүйн байршил болон суралцагчдын тооноос хамаарч ялгамжтай байхаар тогтоожээ.

Сурч боловсрох эрхийн талаар төрийн хүлээх үүргийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 13 дугаар зөвлөмжид хүн бүрд боловсрол олгохын тулд боловсрол нь хүрэлцээтэй¹, хүртээмжтэй², хүлээн зөвшөөрөгдсөн³, нийцэн зохицсон⁴ байх гэсэн 4А-гийн зарчимд тулгуурласан байх ёстойг тайлбарласан байдаг. “Хүртээмжтэй байх зарчим нь үл ялгаварлан гадуурхах, биет хүртээмж, эдийн засгийн хүртээмжтэй байдал” хэмээх 3 хэмжигдэхүүнтэй байна. Төрөөс боловсролыг хүртээмжтэй байлгах үүрэг нь боловсролын салбарт аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бүрэн хориглосон эсэх, хүн бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг байна.

¹ Боловсролын байгууллага болон хөтөлбөр хангалттай хэмжээнд байх ёстой утгыг илэрхийлнэ. Тухайн боловсролын байгууллагаас үйл ажиллагаа явуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг нөөц, тухайлбал, шаардлагад нийцсэн байр, багшлах боловсон хүчин, номын сан, компьютер, мэдээллийн технологи хэрэгслүүдийг хангалттай хэмжээнд бүрдүүлсэн байх шаардлагатай.

² Боловсрол нь ямар нэгэн ялгаварлалгүйгээр хүн бүхэн бүхэнд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэй байх шаардлагатай (non-discrimination). Боловсролыг хүртэх, хүлээн авах нь бие махбодын хувьд аюулгүй байхын зэрэгцээ, хамрагдахад газар зүйн байрлалын хувьд тохиромжтой байх шаардлагатай (physical accessibility). Боловсролыг хүн бүр хүртэхүйц байх шаардлагатай. Хүн бүрд бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. (economic accessibility).

³ Боловсролын хэлбэр, агуулга, тухайлбал сургалтын хөтөлбөр, багшлах арга зүй нь соёлын хувьд тохиромжтой, чанарын шаардлага хангасан бөгөөд суралцагч болон тэдгээрийн эцэг, эхчүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай.

⁴ Боловсрол нь уян хатан байх ёстой бөгөөд ингэснээр өөрчлөгдөж буй нийгэм, олон нийтийн хэрэгцээнд дасан зохицож, суралцагчдын нийгэм, соёлын янз бүрийн нөхцөлд тэдний хэрэгцээг хангах боломжтой болно.

Тиймээс нийгмийн эмзэг бүлэг буюу маргинальчлагдсан бүлгийн эрх болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэстний цөөнх, малчдын хүүхэд, шилжин суурьшигчдын хүүхэд, амьжиргааны түвшнээс доогуур өрхийн хүүхдүүд, жирэмсэн охид, хүүхэд төрүүлсэн өсвөр насны охид, төвөөс алслагдсан нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж хангагдаж чадсан эсэхээр энэхүү зарчмын хэрэгжилтийг хэмжих боломжтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдлын зарчмыг үйл ажиллагаандаа чиглэл болгон баримтлахыг төрд үүрэгжүүлжээ. Тэгш байдлын зарчим нь өргөн агуулгатай бөгөөд хүн бүрийн хууль ёсны ашиг сонирхлыг адил тэгш хүндэтгэж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломж бүрдүүлэхийг шаарддаг. Тэгш боломж бүрдүүлэх гэдэгт төрөөс нийгмийн шударга ёсыг хангахад чиглэсэн шаардлагатай зохицуулалт хийхийг ойлгоно. Уг зарчмын дагуу нийгэмд тэгш байдал тогтоох зорилгоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүргийг төрд хүлээлгэдэг. Тухайлбал, нийгэм, эдийн засаг, улс төрийн эрх, эрх чөлөөг тэгш эдлүүлэх зорилгоор үндэслэл бүхий давуу байдал олгох нь үүнд хамаарна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах ... тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй,” гэж зарим иргэдэд үндэслэл бүхий давуу байдал олгохоор зохицуулсан. Ийнхүү тэгш байдлын зарчмын хүрээнд үндсэн эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдэлж чадахгүй байгаа иргэдэд тэгш боломж олгохын тулд үндэслэл бүхий ялгаатай бодлого хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн байна.⁵

2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 797,905 хүүхэд суралцаж байгаагаас хамран сургах тойргийн 512,425, хамран сургах тойргийн бус 285,480 хүүхэд байна. Үүнээс 6,273 нь буюу 0.78 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 136,730 нь буюу 17,1 хувь нь малчин өрхийн хүүхэд байна. Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 264,818 хүүхэд хамрагдсанаас үндсэн сургалтад 253,158, хувилбарт сургалтад 11,660, малчин өрхийн 32,282, хөгжлийн бэрхшээлтэй 2,150 хүүхэд байна.⁶

Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгод “2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендэрийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлсэн ч эдгээр бүлгийн хүүхдүүдийн хувьд тэгш хамруулсан чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдахад олон төрлийн саад бэрхшээл тулгарсан хэвээр байгааг цөөнгүй судалгаанд илтгэсэн байдаг.⁷

Нийслэл болон аймгийн төвүүд нь нэгдсэн дэд бүтцэд холбогдсон, төвлөрсөн төрийн үйлчилгээтэй эдийн засаг, нийгмийн үзүүлэлт нь харьцангуй тогтвортой, хүн амын тооноос хамаарч ажиллах хүчний нөөц их зэрэг сумдтай харьцуулахад давуу тал ихтэй. Гэтэл хүн ам цөөтэй орон нутагт сургуулийн тоо цөөн, дэд бүтэц, хүний нөөц хязгаарлагдмал, орон нутгийн сургуулиуд дэд бүтэцтэй холбоотой төрөл бүрийн хүндрэлтэй тулгарч байна. Тухайлбал, багш, ажиллагсдыг хурал, сургалтад хамруулахад тээврийн зардал өндөр, төрийн үйлчилгээ хязгаарлагдмал, дэд бүтэц сайн хөгжөөгүй, нэг багшид оногдох сурагчийн тоо хот суурины сургуулийнхтай харьцуулбал цөөн байна.

Бүх шатны боловсролын байгууллагад суралцагчид ногдох хувьсах зардлыг ижилхэн дүнгээр тогтоож, хүүхдийн тооноос хамаарч олгох нь боловсролын тэгш бус байдлыг бий болгох сөрөг үр дагавартай юм. Боловсролын ерөнхий хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль,

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2025, №05

⁶ Боловсролын яам, ЕБС, СӨББ-ын статистик мэдээллээс

⁷ ЮНЕСКО, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, УБ хот, 2019 он.

политехник коллежийн үйл ажиллагааны зардлын бүрэлдэхүүнийг харгалзан тооцож, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулжээ. Тухайлбал, хүүхдийн тоо, бүлэг дүүргэлт, хүчин чадлын ашиглалт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, нэмэлт хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, сургалтын цахим хэрэглээ, сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, боловсролын стандарт, багш ажилтны дундаж цалин хөлснөөс хамаарсан сургалтын үйл ажиллагааны хувьсах зардлыг олгохоор байна.⁸

Түүнчлэн хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батлахаар заасан байдаг.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг үндэслэн боловсролын байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг тооцож төсөв хуваарилдгаас үзэхэд сумын цэцэрлэг, сургуулийн анги дүүргэлт, суралцагчийн тоотой уялдуулан хувьсах зардлыг тооцвол сумдад үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны хувьсах зардал маш бага, нийслэл болон аймгийн төвийн суманд байршилтай цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны хувьсах зардал суралцагчийн тооноос хамаарч харьцангуй өндөр болсноор тэгш бус байдал улам нэмэгдэх эрсдэлтэй байна.

Иймд зарим тохиолдолд хүмүүсийн бүлэг хоорондын нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй ашиг сонирхлыг хангах зорилгоор ялгамжтай хандах нь тэгш байдлыг хангах нөхцөл болдог. Өнгөрсөн хугацаанд нийгэмд нэгэнт бий болсон тэгш бус байдлын сөрөг үр нөлөөг бууруулахын тулд хуулиар иргэдэд ялгамжтай хандах нь тэгш байдлын зарчимд нийцнэ гэж Үндсэн хуулийн цэц дүгнэжээ.⁹

Боловсролын салбарын статистикийн мэдээлэлд тусгагдсанаар 2024-2025 оны хичээлийн жилд бүлэг дүүргэлтийн улсын дундаж төрийн өмчийн сургуульд 31.6 байгаа нь хувийн өмчийн сургуулиас 9.3 пунктээр өндөр, орон нутагт бүлэг дүүргэлт дунджаар 28.1, хотод бүлэг дүүргэлт 33.2 байгаа ажээ. Сум, баг, хороо, тосгонд байрлах 9 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиудын бүлэг дүүргэлт улсын дунджаас доогуур байгаа бөгөөд аймгийн төвийн сургуульд бүлэг дүүргэлт 30.7, сумын сургуульд 24.5 байхад баг, хороо, тосгоны сургуульд 18.2 болж буурч байна. Бүс нутгаар авч үзвэл хангайн бүсийн сургуулиуд дундаж үзүүлэлтээр хамгийн доогуур байхад Улаанбаатарт хамгийн өндөр байна.¹⁰

Түүнчлэн Монгол Улсын 330 сумын 80 хувь нь аймгийн төвөөс 100 км-ээс хол байрлах бөгөөд малчин өрхүүд сумын төвөөс 10-55 км алслагдан нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг байна.¹¹ “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний зөвлөлөөс хийсэн судалгаанд 2023-2024 оны хичээлийн жилд 1-9 дүгээр ангийн сургуулиас гадна байгаа нийт 454 хүүхэд байна. Үүний 231 буюу 50.8 хувь нь малчдын хүүхэд байгаагаас үзэхэд хөдөөд бүлэг дүүргэлт цөөрч буй нь боловсролын үйлчилгээ тэгш хамруулах зарчмыг дэмжин үр ашгийг тэнцвэржүүлэх үндэслэл шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сурч боловсрох эрхийн тухай тусгай илтгэгчийн илтгэлд “Боловсролын салбарт ч бас шинэ тутам асуудлууд ажиглагдаж байгаагийн дотор сургуулийн нөхцөл байдал муудсан, хичээл заах аргын болон сурлагын чанар доройтсон (ялангуяа хөдөө орон нутгийн сургуулиудад), хүүхдүүд сургуулиас гадуур амралт чөлөөт

⁸ Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.2 дахь заалт

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2025, №05

¹⁰ ЮНЕСКО, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, УБ хот, 2019 он.

¹¹ ЮНЕСКО, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, УБ хот, 2019 он.

цагаа зохисгүй байдлаар өнгөрөөх болсон сургууль завсардалтын түвшин өссөн байна, ... хүүхдүүдийн бага дунд сургуулиас завсардаж байгаа хувь хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол олох хязгаарлагдмал боломж, эдгээр болон бусад үзэгдлийн тухайд баталгаатай тоо баримт байхгүй, ... сургуулийн барилга, дотуур байр нь хуучирч муудсан, зарим тохиолдолд шаардлага хангахгүй, Хөдөө орон нутагт тааруухан нөхцөл байдал дээр усны болон, эрүүл ахуйн асуудал муудаж байгаа нь хөдөөгөөс хот руу чиглэсэн нүүдлээс болоод хотын сургуулиуд ачаалал нь хэтрэх хүндрэлд ороод байна.”¹² гэж тусгагджээ. Хөдөө орон нутагт боловсролын чанар, хүртээмжийн хангалтгүй байдал нь хүүхдэдээ сайн боловсрол эзэмшүүлэх гэсэн иргэдийн төв, суурин газарт шилжих хөдөлгөөн нэмэгдэх нэг шалтгаан болж байна.

Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээгээр орон нутгийн сургуулийн чанар, чадавхыг сайжруулж, сурагчдыг элсүүлж, тогтоон барих нь боловсролын салбарын тулгамдсан асуудал бөгөөд хот, хөдөөгийн оршин суугчдын тэнцвэрт бус тархалтаас үүдэн нийгэм эдийн засгийн сөрөг үр дагавар нэмэгдэж байгааг шийдвэрлэхийн тулд үндэсний хэмжээнд тогтвортой, интеграцчилсан хөгжлийн бодлогыг боловсруулж, боловсролын чанар, хүртээмжтэй байдалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч Монгол Улсын Засгийн газарт “...боловсролд зохих хөрөнгө оруулалтыг хийж, Боловсролын яамны төсөвт шаардлагатай санхүүжилтүүдийг (доод тал нь ДНБ-ний 6 хувь буюу Улсын төсвийн 20 хувьтай тэнцэх) хуваарилан зарцуулах, эдийн засаг, санхүүгийн хямралтай нөхцөлд ч гэсэн тогтвортой, хангалттай санхүүжилт хийхэд анхаарах, сургуулийн дэд бүтцийн асуудлыг, ялангуяа хөдөө нутгуудад анхаарах, ус урсдаг ариун цэврийн байгууламж бүхий, шаардлага хангахуйц халаалттайгаар сургуулиудыг шинэчлэх хөтөлбөр боловсруулах; сургуулиудын ачаалал хэтэрсэн хот болон хотожсон газруудад шинээр суурьшсан хүн амын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр тэргүүлэх зорилтын нэг болгож сургуулиудын барилгыг өргөтгөх” зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна.¹³

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Боловсролын талаар алагчлахгүй байх тухай конвенцын 4 дүгээр зүйлд “оролцогч улсууд боловсролын талаар адил тэгш бололцоог олгох, харилцаанд дөхөм үзүүлэх хийгээд үндэсний нөхцөл байдал, зан заншилд нийцүүлэн хэрэгжүүлэх төрийн бодлого боловсруулан хөгжүүлж, амьдрал ахуйд нэвтрүүлэх үүрэгтэй, (b) улсын адил шатны бүх сургуульд адил боловсрол олгох, түүний сургалтын чанар ижил байх нөхцөлийг хангах” гэж тусгасан байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Сурч боловсрох эрхийн талаарх Ерөнхий санал, зөвлөмж 13-т “Боловсрол гэдэг нь өөрөө хүний эрх бөгөөд бусад эрхийг хангах үндэс нь болдог. Ялгаварлан гадуурхах байдал гаргахгүй байх - Боловсрол нь хуулийн хүрээнд ч, бодит амьдрал дээр ч бүх хүмүүсийн хувьд нээлттэй байх хэрэгтэй. Ялангуяа нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд ч нээлттэй байх ёстой ба ямар нэгэн ялгаварлан гадуурхах шалтгаан, үндэслэл огт байж болохгүй. Нийгмийн эмзэг бүлгийнхэнд зориулсан тэгш байдлыг бий болгох түр хугацааны арга хэмжээг авах нь боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг зөрчиж байгаа явдал биш юм. Яагаад гэвэл эдгээр арга хэмжээний дагуу тавьсан зорилгодоо нэгэнт хүрсний дараа үргэлжлүүлэн явуулахгүй юм. Бодлогыг шударга бусаар харилцан адилгүй байдлаар хэрэгжүүлэх нь өөр өөр газар зүйн байрлалд амьдарч байгаа хүмүүст өөр өөр чанартай

¹² Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс. Хоёрдугаар боть, УБ хот, 2021,849 тал

¹³ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс. Хоёрдугаар боть, УБ хот, 2021,855 тал

боловсрол эзэмшүүлэх үр дагаврыг гаргах ба энэ нь Пактын хүрээнд ялгаварлан гадуурхах байдлыг бүрдүүлж байгаа хэрэг болно” гэжээ.

Түүнчлэн, мөн хорооноос гаргасан (Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг ялгаварлан гадуурхахгүй байх) ерөнхий тайлбар 23-т “2.8.(б)-д Материаллаг ялгаварлан гадуурхалт: Зөвхөн албан ёсны ялгаварлан гадуурхах асуудлыг шийдвэрлэх нь пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэгш байдлыг хангахгүй. Практикт ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд ижил төстэй нөхцөл байдалд байгаа хүмүүсээс илүүтэй байнгын гадуурхалд өртөж буй хэсэг бүлэг хүмүүст анхаарал хандуулах шаардлагатай. Иймд оролцогч улсууд материаллаг болон бодитойгоор ялгаварлан гадуурхалтыг бий болгох нөхцөл, хандлагаас урьдчилан сэргийлэх, багасгах, арилгахад шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах ёстой. Тухайлбал, ... хөдөө орон нутагт амьдарч буй хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдлыг даван туулахад туслах.” гэж тусгасан байна.

Эдгээрээс харахад боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанартай боловсрол олгох, сурч боловсрох тэгш боломжоор хангах зорилгоор авч буй энэ арга хэмжээ нь олон улсын гэрээ конвенцоор зөвшөөрөгдсөн арга хэмжээ гэж үзэхээр байна.

1/Засгийн газар дотоодын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүний хэмжээг ажилласан жилтэй нь уялдуулан ялгамжтай тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан цалин хөлс авах, үл ялгаварлан гадуурхах эрхийг хангахад чиглэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Цаашид төрийн албанд 26 болон түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагчид олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг улсын төсөв, эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан тодорхой хэмжээгээр үе шаттайгаар нэмэгдүүлэн олгох арга хэмжээг судалж, хэрэгжүүлэх нь олон улсын гэрээ, конвенцын заалтад нийцнэ.

2/Хуулиар ялгамжтай хандсан тохиолдол бүрийг ялгаварлан гадуурхахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж, төрийн хууль ёсны зорилгод хүрэхэд тохирсон, үндэслэл бүхий ялгаварлалыг ялгаварлан гадуурхсан гэж үзэхгүй хэмээн Үндсэн хуулийн цэц дүгнэжээ. Тус дүгнэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байдал болон хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын хүрээнд Үндсэн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхалт үүсэхээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах зорилгоор хуулиар ялгамжтай хандахыг зөвшөөрдөг¹⁴ гэж дурджээ.

Хот суурин газрын сургуулийн ачаалал хэт ихсэж, хөдөө орон нутагт элсэлт буурч байгаагаар холбогдуулан боловсролын тэгш боломж болон тэгш хамруулах зарчмыг хангахуйц, тэнцвэртэй хөрөнгө оруулах талаар бодлогыг тодорхойлох шаардлагатай болж, үүнээс хамаарч газарзүйн байршил болон хүүхдийн тоотой уялдуулан хувьсах зардлын итгэлцүүрийг тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан сурч боловсрох үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг хангагдахад чиглэгдсэн гэж үзэх боломжтой юм.

Дөрөв. Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд хөдөлмөрлөх эрхийн талаар 13 удаа, сурч боловсрох эрхийн талаар 10 удаа тусгасан. Мөн 22 дахь илтгэлд Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал бүлгийн хүрээнд Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, хууль тогтоомжийн өөрчлөлт, Төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн зарим асуудлыг, 23 дахь илтгэлд Боловсролын салбар дахь

¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2025, №05

хүний эрхийн нөхцөл байдал бүлгийн хүрээнд багш ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, тэгш хамруулах зарим асуудлыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 35 дугаар тогтоолын 1.5.б-д "Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар тодорхойлох, цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авах"-ыг Засгийн газарт даалгасан болно.

ДАРГА



Д.СҮНЖИД